

Э-Сонин

38 дахь дугаар

Мэдээний Тойм



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЭ ОРЧИН БҮРДЭЖ ЭХЭЛЛЭЭ



АНХНЫ ДААТГАДСАН БОНД АМЖИЛТТАЙ БОЛЛО

"ЗООС ГОЁЛ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ СЭРГЭЭЛЭЭ



ТОП-20 ИНДЕКСИЙН САГС ШИНЭЧЛЭГДЛЭЭ



СУРГАЛТ

ТӨГСӨЛТИЙН БАЯР

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт”-ыг 2016 оны 3 дугаар сарын 21-ны өдөр явуулахаар төлөвлөж байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг 11-313747 -126 дугаараас авна уу.

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- ЗГЖҮЦ-ны 2 дугаар сарын арилжааны мэдээлэл.
- Монголын анхны даатгагдсан компанийн бонд болох “Эрчим бонд”-ын эргэн төлөлт болон хүүний төлбөрийг 2016 оны 2-р сарын 19-ны өдөр “Эрчим Инженеринг” ХХК –наас хөрөнгө оруулагч нарт бүрэн хийгдсэн байна.
- TOP-20 хувьцаат компани сайн засаглалыг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллахаар боллоо.
- 2015 он сүүлийн хагас жилийн үзүүлэлтээр шалгарсан ТОП-20 компани 2016 оны эхний хагас жилд индексийн сагсыг бүрдүүлнэ.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ


- 2-р сарын арилжааны мэдээ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭЛЭЛ

Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны /Нэгжийн үнэ 100,000 төгрөг/ захиалгыг долоо хоног бүрийн Мягмар гарагаас дараа долоо хоногийн Даваа гараг хүртэл авч, арилжааг зохион байгуулж байна. Хоёрдугаар сард тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг 5 удаа зохион байгуулж нийт 12.3 тэрбум төгрөгийн богино болон урт хугацаат ГЗҮЦ-ыг арилжаалсан байна.

Өдөр	Хугацаа /7 хоног/	Зарагдсан тоо хэмжээ /ш/	Хүүгийн хэмжээ	Үнийн дүн /төгрөг/
2016.02.01	28	22,399	14.108%	2,082,166,242.00
2016.02.08	52	549	14.941%	47,780,563.00
2016.02.08	156	610	15.750%	61,000,000.00
2016.02.17	28	4,800	14.215%	445,958,400.00
2016.02.22	12	100,000	13.635%	9,695,800,000.00
2016.02.22	156	180	15.750%	18,000,000.00
2016.02.29	39	65	14.915%	5,847,660.00
НИЙТ ЗАРАГДСАН ЗГҮЦ		128,603		12,356,552,870.00



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШИНЭ ОРЧИН БҮРДЭЖ ЭХЭЛЛЭЭ

Монголын хөрөнгийн бирж, Компанийн засаглалын үндэсний зөвлөл болон ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлэгч хувьцаат компаниудын ТУЗ-ийн дарга нар Сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах “ТУНХАГ БИЧИГ”-т гурвалсан гарын үсэг зурж, “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ийг зайлшгүй дагаж мөрдөх, түүнд тусгасан ил тод, нээлттэй, эрх тэгш, хяналттай, хариуцлагатай ажиллах сайн засаглалыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн ажиллах олон арга хэмжээг хамтран хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ.

ТОП-20 индексийн сагс шинэчлэгдэн, "Мерекс", "Ариг гал", "Э-транс ложистикс" болон "Хай би ойл" хувьцаат компаниуд нэмэгдэж, Сайн засаглалтай хувьцаат компани болохоор хичээж ажиллах “ТУНХАГ БИЧИГ”-т нэгдэн гарын үсэг зурж, баталгаажуулах ёслолын арга хэмжээ 2016 оны 2 дугаар сарын 19-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн байранд зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж болон Компанийн засаглалын үндэсний зөвлөл хамтран зохион байгуулж, ТОП-20 индексийн сагсыг бүрдүүлэгч хувьцаат компаниудад Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-ын шинэчлэл, Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс "Мэдээллийн ил тод байдлыг хангуулах нь", "Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам"-ын талаар, Монголын хөрөнгийн биржийн зүгээс "Бүртгэлийн журам"-ын өөрчлөлт, "Мэдээллийн журам"-ын шинэчлэл болон "МХБ-д бүртгэлтэй компанийн компанийн засаглалын байдал, цаашдын анхаарах асуудал"-ын талаар танилцууллаа.

Мөн Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирал М.Болор хувьцаат компаниудын удирдлагуудад хандан Хөрөнгийн зах зээлийн шинэ орчин болон бүртгэлтэй хувьцаат компаниуд хэрхэн нэмэлт санхүүжилт татах шинэ боломжуудын талаар танилцуулга хийлээ.



АНХНЫ ДААТГАДСАН БОНД АМЖИЛТТАЙ БОЛЛОО

“Эрчим Инженеринг” ХХК-ийн гаргасан Монголын анхны даатгагдсан компанийн бонд болох “Эрчим бонд”-ын анхдагч зах зээлийн арилжаа 2015 оны 8-р сарын 21-нд Монголын хөрөнгийн бирж дээр амжилттай арилжаалагдсан билээ.

“Эрчим бонд” нь 182 хоногийн хугацаатай жилийн 18.5 хувийн хүүтэй, үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааны эцэст нэг удаа төлөгдөхөөр хямдруулсан нөхцөлтэйгөөр хөрөнгө оруулагчдад санал болгогдсон ба анхдагч зах зээл дээр нийтдээ 2.4 тэрбум төгрөгийн дүн бүхий буюу анхны нийлүүлэлтээс 4 дахин давсан худалдан авах захиалга хүлээн авч анхдагч зах зээлийг эхлүүлж байв.

Тус бондын андеррайтераар Голом банк, туслах андеррайтераар Голомт Секюритиз ҮЦК, бондын 100% эргэн төлөлтийн даатгагчаар Соёмбо Даатгал нар тус тус оролцсон бөгөөд бондын үндсэн төлөлтийн эргэн төлөлт болон хүүний төлбөрийг 2016 оны 2-р сарын 19-ны өдөр “Эрчим Инженеринг” ХХК –наас хөрөнгө оруулагч нарт бүрэн хийгдэв.

"ЗООС ГОЁЛ" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ СЭРГЭЭЛЭЭ

"Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлын 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 31 дугаар тушаалаар "Зоос гоёл" MSE:ZOO хувьцаат компанийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрэлсэн үнэтэй 288 ширхэг хувьцааг нэг бүр нь 28,800 төгрөгийн нэрэлсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд хөрвүүлэх замаар нэгтгэн, нийт гаргасан 3,754,944 ширхэг энгийн хувьцааг 13,038 ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсан билээ.

"Зоос гоёл" ХК-иас хувьцаа нэгтгэх төслийн хэрэгжилтийн тайлан болон холбогдох бусад баримт материалыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн тул 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 03 тоот Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн албан шаардлагын дагуу "Зоос гоёл" ХК-ийн үнэт цаасны арилжааг 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдрөөс сэргээлээ.

ТОП-20 ИНДЕКСИЙН САГС ШИНЭЧЛЭГДЛЭЭ

2015 оны сүүлийн хагас жилийн үзүүлэлтээр шалгарсан ТОП-20 компани 2016 оны эхний хагас жилд индексийн сагсыг бүрдүүлнэ.

Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны үнийн индекс тооцох тухай журам”-ын 2-р зүйлийг үндэслэн ТОП-20 индексийн багцыг 2016 оны эхний хагас жилд бүрдүүлэх үнэт цаасуудыг дараах байдлаар сонгон шалгаруулав. Үүнд:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Зах зээлийн үнэлгээ	Арилжаанд орсон өдөр /127 өдөр/	Өдрийн дундаж гүйлгээ
1	APU	АПУ	289,424,879,200	119	2,359,451
2	GOV	ГОВЬ	66,153,540,000	93	1,320,252
3	BDS	БИ ДИ СЕК	32,963,000,000	27	3,992,214
4	TTL	ТАВАН ТОЛГОЙ	76,127,405,000	76	485,377
5	NEH	ДАРХАН НЭХИЙ	20,174,991,750	45	551,301
6	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	19,508,160,500	82	8,107,054
7	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	20,307,120,000	33	430,179
8	TCK	ТАЛХ ЧИХЭР	17,791,958,140	70	744,190
9	BAN	БАГАНУУР	12,951,667,300	62	272,927
10	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	9,630,942,783	53	907,754
11	MMX	МАХИМПЕКС	10,794,047,640	55	258,394
12	SHG	ШАРЫН ГОЛ	39,175,772,184	59	197,723
13	EER	АРИГ ГАЛ	8,176,402,000	45	155,315
14	HVO	ХАЙ БИ ОЙЛ	21,889,960,680	32	134,867
15	ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	5,544,000,000	47	972,485
16	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	7,500,000,000	61	116,461
17	HGN	ХӨХ ГАН	7,551,197,523	51	109,349
18	MRX	МЕРЕКС	4,810,370,000	70	250,196
19	SHV	ШИВЭЭ ОВОО	4,727,548,930	34	98,434
20	BUK	УБ-БУК	52,092,810,000	32	85,676

2015 оны сүүлийн хагас жилийн үзүүлэлтээр ТОП-20 индексийн сагсыг шинэчлэхэд өмнөх сагсад багтаж байсан 16 компани хэвээр үлдэж, “Монголын цахилгаан холбоо”, “Материалимпекс”, “Фронтриер лэнд групп”, “Ремикон” ХК-ууд хасагдаж, шинээр “Мерекс”, “Ариг гал”, “Э-транс ложистикс”, болон “Хай би ойл” ХК-ууд нэмэгдэн шинэчилсэн сагсыг бүрдүүлж байна.



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ

ТӨГСӨЛТИЙН БАЯР



Монголын Хөрөнгийн Биржийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2016 оны 2 дугаар сарын 22-ноос 2 дугаар сарын 26-ны хооронд явагдаж дууслаа.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтад цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2016 оны 3 дугаар сарын 21-ны өдрөөс явуулахаар төлөвлөж байна.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье





МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

MONGOLIAN STOCK EXCHANGE

Веб: www.mse.mn Утас: (976)-11-310456 Факс: (976)-11-325170 Email: trading_ml@mse.mn Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай-2

САРЫН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2016 оны 02 дугаар сар

Арилжааны товч мэдээ


Арилжигдсан ширхэг	973 537
Нийт үнийн дүн /Төг/	16 041 922 334,55
Хэлцлийн тоо	1 163
Арилжигдсан үнэт цаасны тоо	71
Зах зээлийн үнэлгээ /Төг/	1 446 081 191 204

ТОП-20 индекс

Хаалт	11 968,37
Өөрчлөлт /%/	1,94

MSE ALL индекс

Хаалт	862,64
Өөрчлөлт /%/	0,76



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүнгээр:			
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	№	Симбол	Үнэт цаасны нэр	Үнийн дүн
1	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	330 585	1	APU	АПУ	522 798 770
2	APU	АПУ	147 711	2	MBG	МОН-ИТ БУЛИГААР	263 649 600
3	MBG	МОН-ИТ БУЛИГААР	146 472	3	SUU	СҮҮ	73 372 200
4	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	93 682	4	GOV	ГОВЬ	66 744 220
5	MRX	МЕРЕКС	18 415	5	MNP	МОНГОЛ ШУУДАН ХК	29 199 103

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	BVD	СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	107,39		131,24
2	MIE	МАТЕРИАЛИМПЕКС	11 890,00		47,61
3	NEH	ДАРХАН НЭХИЙ	24 040,00		26,53
4	SUU	СҮҮ	128 400,00		22,29
5	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	88,00		18,92

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					%
1	TTL	ТАВАН ТОЛГОЙ	1 889,00		-30,81
2	ONH	ӨНДӨРХААН	7 400,00		-26,00
3	BEU	БЭРХ УУЛ	1 650,00		-24,49
4	MIB	МОНИНЖБАР	110,12		-15,32
5	BTG	БАЯНТЭЭГ	14 440,00		-15,01

Засгийн газрын үнэт цаас: /анхдагч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Үнэ	Хугацаа /долоо хоног/	Хүүгийн хэмжээ %
1	ЗГХБ-Б-28-352	22 399	2 082 166 242	92 958	28	14,108
2	ЗГХБ-Б-52-353	549	47 780 568	87 032	52	14,941
3	ЗГЭБ-У-156-354	610	61 000 000	100 000	156	15,750
4	ЗГХБ-Б-28-355	4 800	445 958 400	92 908	28	14,215
5	ЗГХБ-Б-12-356	100 000	9 695 800 000	96 958	12	13,635
6	ЗГЭБ-У-156-357	180	18 000 000	100 000	156	15,750
7	ЗГХБ-Б-39-358	65	5 847 660	89 964	39	14,915

Засгийн газрын үнэт цаас: /хоёрдогч зах зээл/

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн	Дээд ханш	Доод ханш	Сүүлчийн ханш
1	ZGEB-BL-16/02/16-A0078-0	25 299	2 518 009 470	99 530	99 530	99 530
2	ZGEB-BL-22/03/16-A0053-0	610	59 908 100	98 210	98 210	98 210
3	ZGEB-BL-25/07/16-A0094-0	10	943 100	94 310	94 310	94 310